



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/48/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamd@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.0	160.0	160.0
Авлага	1,935.0	0.0	-1,935.0
Бараа материал	14,598.2	16,133.2	1,535.0
Үндсэн хөрөнгө	1,410,264.1	1,710,362.2	300,098.1
Нийт хөрөнгө	1,426,797.3	1,726,495.4	299,698.1
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,426,797.3	1,726,495.4	299,698.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,426,797.3	1,726,495.4	299,698.1

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,491.5 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, 2 төлбөрийн акт тогтоосон.

5.1 Төлбөрийн акт

1. Улаан-Уул сумын ЗДТГ нь 2023 онд төсвийн хөрөнгөөр баяр наадамд хэрэглэх зорилгоор нийт 2,049.1 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна. Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 15.1.6 дахь, "Төсвийн тухай хууль"-ийн 16.5.5² дахь заалттай тус тус нийцэхгүй бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

2. Улаан-Уул сумын ЗДТГ нягтлан бодогчоор ажиллаж байсан Цэвээнравдан нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн боловч 3,445.9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1 "Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно", 80.1.1, 80.1.2, 80.1.3 дахь заалттай тус тус нийцээгүй ба "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн зарцуулалт	1	2,049.1	1	2,049.1								
Төсвийн зарцуулалт	1	3,445.9	1	3,445.9								
Дүн	2	5,495.1	2	5,495.1								

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/89
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА М.БАТЦОГТ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 299,698.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 онд төсвийн хөрөнгөөр баяр наадамд хэрэглэх зорилгоор нийт 2,049.1 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь нь Улаан-Уул сумын Засаг даргаар 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, түүнийг 98.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

